



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/А83

Булган сум

Үндэсний бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээний тамирчдад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.6.1, 2023 оны “Булган аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” XVII/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны “Хөтөлбөр төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг тодотгон батлах тухай” А/593 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотноо 2023 оны 11 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулагдах Үндэсний бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд багш, дасгалжуулагч Ц.Баттулга нь баг, тамирчдын хамт оролцох болсон тул замын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Замын зардалд шаардагдах 395,000 (гурван зуун ерэн таван мянга) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал”-аас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ